



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/435

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэдээлэл, харилцаа холбооны салбарт хамт олноо манлайлан аймаг, орон нутгийн хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулан үр бүтээлтэй ажиллаж буй нэр бүхий иргэдийг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 60000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 60000 төгрөг /жаран мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 14-ний өдрийн
А/435 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС**

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Мөнгөн дүн
1	Б.Цэвэлмаа	Мобикомын Ховд салбарын борлуулалтын ажилтан	30000
2	П.Баянжаргал	Мобикомын Ховд салбарын үйлчилгээний ажилтан	30000
Дүн			60000

-oOo-